



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/04/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор Н.Энхчимэг Утас: 703333019 Цахим хаяг: Enkhchimeg@audit.gov.mn</p>
--------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
Агуулга.....	1
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Аудитын тайлан.....	7
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	11
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	11
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4.2. Албан шаардлага	12
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13

Товчилсонүгийнжагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББТХууль	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар

АРХАНГАЙ АЙМГИЙН МУЗЕЙН ДАРГА
Т. МӨНХБҮРЭН ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА

Архангай аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн аудитын тайлан

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхнийүлдэгдэл	Эцсийнүлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	29,790,338.08	33,414,818.08
35	БАРАА МАТЕРИАЛ	29,790,338.08	33,414,818.08
35400	Хангамжийнматериал	29,790,338.08	33,414,818.08
35420	Ажахуйнматериал	2,527,088.56	4,171,068.56
35440	Түлш, шатахтослохматериал	2,910,003.00	3,750,003.00
35470	Бусадхангамжийнматериал	24,353,246.52	25,493,746.52
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,555,631,436.98	1,545,447,003.57
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,555,631,436.98	1,545,447,003.57
39200	Биетхөрөнгө	1,509,500,936.98	1,499,882,003.57
39201	Барилга, байгууламж, оронсууц	472,713,011.85	477,713,011.85
39202	Хуримтлагдсанэлэгдэл	-36,015,974.16	-55,389,601.20
39203	Авто-тээврийнхэрэгсэл	27,000,000.00	27,000,000.00
39204	Хуримтлагдсанэлэгдэл	-27,000,000.00	-27,000,000.00
39205	Машинтоногтөхөөрөмж(компьютер)	103,529,182.00	113,239,182.00
39206	Хуримтлагдсанэлэгдэл	-96,119,899.50	-98,596,111.06
39207	Тавилга, ажахуйнэдхогшил	49,001,796.28	47,938,679.28
39208	Хуримтлагдсанэлэгдэл	-32,106,263.39	-34,235,241.20
39213	Түүхсоёл, музейндурсгалтзүйлс	1,045,927,588.00	1,046,080,588.00
39217	Ном	2,571,495.90	3,131,495.90
39300	Биетбусхөрөнгө	46,130,500.00	45,565,000.00
39301	Програмхангамж	2,460,500.00	1,895,000.00
39303	Бусадбиетбусхөрөнгө	43,670,000.00	43,670,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,585,421,775.06	1,578,861,821.65
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,585,421,775.06	1,578,861,821.65
51	Засгийнгазрынхувьоролцоо	1,585,421,775.06	1,578,861,821.65
51100	Засгийнгазрынорлуулсанкапитал /Засгийнгазрынсан/ ороннугийнсан	1,841,397,444.11	1,841,397,444.11
51200	Хуримтлагдсанүрдүн	-1,360,738,059.28	1,367,298,012.69
51210	Өмнөхүеийнүрдүн	-1,413,604,649.63	-
51220	Тайлантүеийнүрдүн	52,866,590.35	-6,559,953.41
51300	Хөрөнгийндахинүнэлгээнийзөрүү	1,104,762,390.23	1,104,762,390.23
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,585,421,775.06	1,578,861,821.65

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

/төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	209,239,910.0	166,345,200.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	69,779,010.00	0
120	Нийтлэг татварын бус орлого	69,779,010.00	0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,038,000.00	0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,038,000.00	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	66,741,010.00	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	139,460,900.0	166,345,200.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,112,200.00	14,710,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	14,710,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,112,200.00	0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	135,348,700.00	151,635,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	135,348,700.00	151,635,200.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	156,373,319.6	171,421,653.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	156,373,319.6	171,421,653.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	153,761,219.6	154,307,833.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	100,643,832.00	92,628,400.00
210101	Үндсэн цалин	80,227,604.93	80,569,514.00
210102	Нэмэгдэл	20,416,227.07	12,058,886.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,584,800.00	12,504,900.00
210201	Тэтгэврийн даатгал	9,559,700.00	8,965,203.52
210202	Тэтгэмжийн даатгал	1,006,300.00	1,207,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	744,686.50	741,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	261,513.50	185,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,012,600.00	1,405,596.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,739,372.00	10,983,700.00
210301	Гэрэл, цахилгаан	2,304,372.00	2,618,733.00
210302	Түлш, халаалт	4,435,000.00	8,110,000.00
210303	Цэвэр, бохир ус	0	254,967.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,160,030.00	2,856,769.00
210401	Бичиг хэрэг	872,430.00	117,326.00
210402	Тээвэр, шатахуун	535,600.00	1,405,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	960,000.00	1,142,443.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	792,000.00	192,000.00
2105	Нормативт зардал	1,111,720.00	691,015.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,111,720.00	691,015.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,210,800.00	4,195,000.00
210604	Урсгал засвар	3,210,800.00	4,195,000.00
2107	Томиллолт, зочны зардал	800,000.00	866,700.00
210701	Гадаад албан томиллолт	0	0
210702	Дотоод албан томиллолт	800,000.00	866,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	1,967,151.44	4,539,416.00

Архангай аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн аудитын тайлан

	хураамж		
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,563,951.44	4,150,396.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	389,020.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,543,514.21	25,041,933.41
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,543,514.21	25,041,933.41
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,612,100.00	17,113,820.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	94,000.00	17,071,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	16,655,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	94,000.00	416,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,518,100.00	42,120.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,518,100.00	42,120.00
213404	Хөрөнгийн	0	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	52,866,590.35	-5,076,453.41
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	1,483,500.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0	1,483,500.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	52,866,590.35	-6,559,953.41

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,841,397,444.11	1,104,762,390.23	-	1,532,555,184.71
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,841,397,444.11	1,104,762,390.23	1,413,604,649.63	1,532,555,184.71
9	Тайлант үеийн үр дүн	0	0	52,866,590.35	52,866,590.35
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,841,397,444.11	1,104,762,390.23	-	1,585,421,775.06
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,841,397,444.11	1,104,762,390.23	1,360,738,059.28	1,585,421,775.06
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,841,397,444.11	1,104,762,390.23	1,360,738,059.28	1,585,421,775.06
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-6,559,953.41	-6,559,953.41
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,841,397,444.11	1,104,762,390.23	-1,367,298,012.69	1,578,861,821.65

Архангай аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

/төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	142,498,900.00	166,345,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,038,000.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,038,000.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,038,000.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,038,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	139,460,900.00	166,345,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,112,200.00	14,710,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,112,200.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	135,348,700.00	151,635,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	135,348,700.00	151,635,200.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	136,300,900.00	150,004,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	136,300,900.00	150,004,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	133,688,800.00	132,890,380.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	100,628,500.00	92,628,400.00
210101	Үндсэн цалин	73,862,272.93	80,569,514.00
210102	Нэмэгдэл	26,766,227.07	12,058,886.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,584,800.00	12,504,900.00
210201	Тэтгэврийн даатгал	9,559,700.00	8,799,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,006,300.00	926,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	805,000.00	741,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	201,200.00	185,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,012,600.00	1,852,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,965,600.00	11,823,700.00
210301	Гэрэл, цахилгаан	2,304,372.00	2,618,733.00
210302	Түлш, халаалт	6,661,228.00	8,950,000.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	254,967.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,483,400.00	4,772,680.00
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	535,600.00	1,405,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	960,000.00	1,162,880.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,787,800.00	1,204,800.00
2105	Нормативт зардал	790,300.00	666,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	790,300.00	666,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,093,000.00	4,563,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	83,300.00
210604	Урсгал засвар	3,093,000.00	4,480,000.00
2107	Томиллолт, зочны зардал	800,000.00	866,700.00
210702	Дотоод албан томиллолт	800,000.00	866,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,343,200.00	5,064,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	940,000.00	4,619,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	445,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,612,100.00	17,113,820.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	94,000.00	17,071,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	16,655,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	94,000.00	416,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,518,100.00	42,120.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,518,100.00	42,120.00
213404	Хөрөнгийн	0.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	6,198,000.00	16,341,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	6,198,000.00	16,341,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,198,000.00	16,341,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,198,000.00	16,341,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,198,000.00	16,341,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-6,198,000.00	-16,341,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

Архангай аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	гүйцэтгэл	Зөрүү	хувь
II	НИЙТЗАРЛАГАБАЦЭВЭРЭЭЛИЙНДҮН	151,635,200.00	151,593,080.00	42,120.00	100.0%
21	УРСГАЛЗАРДАЛ	151,635,200.00	151,593,080.00	42,120.00	100.0%
210	БАРАА, АЖИЛҮЙЛЧИЛГЭЭНИЙЗАРДАЛ	134,563,500.00	134,521,380.00	42,120.00	100.0%
210101	Үндсэнцалин	72,202,100.00	80,569,514.00	8,367,414.00	100.0%
210102	Нэмэгдэл	20,426,300.00	12,058,886.00	8,367,414.00	111.6%
210301	Гэрэл, цахилгаан	3,468,000.00	2,618,733.00	849,267.00	59.0%
210302	Түлш, халаалт	7,015,700.00	8,950,000.00	1,934,300.00	100.0%
210303	Цэвэр, бохирус	1,340,000.00	254,967.00	1,085,033.00	100.0%
2104	Хангамж, барааматериалынзардал	4,814,800.00	4,772,680.00	42,120.00	100.0%
210402	Тээвэр, шатахуун	1,360,000.00	1,405,000.00	-45,000.00	100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийнтөлбөр	1,250,000.00	1,162,880.00	87,120.00	100.0%
213	УРСГАЛШИЛЖҮҮЛЭГ	17,071,700.00	17,071,700.00	0.00	100.0%
2132	Бусадурсгалшилжүүлэг	17,071,700.00	17,071,700.00	0.00	100.0%
213207	Тэтгэвэртгарахадолгохнэгүдаагийнмөнгөнтэтгэмж	16,655,000.00	16,655,000.00	0.00	75.5%
213209	Нэгүдаагийнтэтгэмж, шагналурамшуулал	416,700.00	416,700.00	0.00	127.6%
III	ЗАРДЛЫГСАХУУЖУУЛЭХЭХҮҮСВЭР	151,635,200.00	151,593,080.00	42,120.00	19.0%
32	ОРОННУТГИЙНТӨСВӨӨССАНХҮҮЖИХ	151,635,200.00	151,593,080.00	42,120.00	99.1%
320001	Ороннутгийнтөсвөөс	151,635,200.00	151,593,080.00	42,120.00	100.0%
6	ТӨСВИЙНБУСАДМЭДЭЭЛЛИЙНАНГИЛАЛ	17.00	17.00	0.00	103.3%
61	БАЙГУУЛЛАГЫНТОО	1.00	1.00	0.00	93.0%
610001	Төсвийнбайгууллага	1.00	1.00	0.00	100.0%
62	АЖИЛЛАГСАДЫНТОО	8.00	8.00	0.00	100.0%
620001	Удирдахажилтан	1.00	1.00	0.00	100.0%
620002	Гүйцэтгэажилтан	5.00	4.00	1.00	100.0%
620003	Үйлчлэажилтан	2.00	3.00	-1.00	60.0%
65	ОРОНТООНЫМЭДЭЭЛЭЛ	8.00	8.00	0.00	100.0%
650006	Соёлурлагийнсалбарынтерийнйлчилгээнийалбанхаагч (ТҮСУ)	6.00	6.00	0.00	100.0%
650009	Терийнүйлчилгээнийбусадалбанхаагч (ТҮ)	2.00	2.00	0.00	100.0%

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалынталаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Энхчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Музей 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 13 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Музей нь Түүх соёлын дурсгалт зүйлийг хадгалах, хамгаалах суртчлах дэлгэрүүлэн соёлын үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг Соёлын яамны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мөрддөг хууль, журамд өөрчлөлт дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль 2021.04.08

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийгсонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 151.6 сая төгрөгөөс 1хувиар буюу 1.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 1.0 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 6.5 ая төгрөгөөр буюу 0.4 хувиар буурч материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Бараа материал	29.80	33.40	3.60	12.1
Үндсэн хөрөнгө	1,746.90	1,545.40	(201.50)	-11.5
Нийт хөрөнгө	1,585.40	1,578.90	(6.50)	-0.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,585.40	1,578.90	(6.50)	-0.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,585.40	1,578.90	(6.50)	-0.4

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл 12.1 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 29.8 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 21.7 сая төгрөг нийт 51.5 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 18.1 сая төгрөгийн зарцуулалт гарч, 33.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 11.5 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 1,746,9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 16.3 сая төгрөгөөр нэмэгдэж, актлсан хөрөнгө 2.5 сая тайлант хугацаанд байгуулсан 215.2 сая төгрөгийн элэгдлээр буурч оны эцэст 1,545.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант үеийн үр дүн 6.5 сая төгрөгөөр хуримтлагдсан үр дүн буурсантай холбоотой.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт /сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	135.3	151.6	16.3
Үндсэн үйл ажиллагааны орлого	3.0	-	(3.0)
Нэмэлт санхүүжилтийн орлого	4.1	14.7	10.6
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	66.8	-	(66.8)
Үйл ажиллагааны орлого	209.2	166.3	(42.9)
Цалин, шимтгэлийн зардал	114.2	105.1	(9.1)
Бусад бараа үйлчилгээний зардал	15.1	19.7	4.6
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2.0	4.5	2.5
Бараа үйлчилгээний бусад зардал	22.5	25.0	2.5
Урсгал шилжүүлэг	2.6	17.1	14.5
Үйл ажиллагааны зардал	156.40	171.4	15.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	52.80	-5.10	(57.9)

Аймгийн Музейн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 16.3 сая төгрөгөөр өссөн нь санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн бдугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 282.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 130.5 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 151.6 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 151.6 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс санхүүжилтийг бүрэн авч 151.6 сая төгрөгийг зарцуулж 0.04 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, тайлант онд батлагдсан төсвийг 0.02 хувиар хэмнэж төсвийн хэмнэлтийг бий болгосон байна

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээрэнэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 14.7 санхүүжилт авч аймгийн Засаг даргын захирамжаар 9.7 сая төгрөгөөр хяналтын камер худалдан авсан, 5.0 сая төгрөгөөр дээврийн засварын ажилд зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагаас 2021 оны 7 дугаар сард 4 үзмэр алдсан тул хяналтын камер дохиоллын систем сайжруулахаар Засаг даргын нөөцөөс хөрөнгийг шийдвэрлэж өгсөн байна. Ковид-19 цар тахлын улмаас гадаад, дотоодын иргэд хүлээн аваагүй харин сурагчдад үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн үндсэн 3 зорилтын хүрээнд 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 96 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 151.6 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 100 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, дээд шатны төсөв захирагчийн шийдвэрийн дагуу дараах алдаа зөрчил илэрлээ. Үүнд:

- Музейн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Отгонбаатарт ЗЗНДНТУТХуулийн 29.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 79.1 дэх заалтыг тус тус үндэслэн ээлжийн амралтыг биеэр эдлээгүй тул үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлэх мөнгөн урамшуулал олгохоор Аймгийн Засаг даргын 2021 оны 12 сарын 15-ны өдрийн б/48 тоот захирамж гарсан боловч ээлжийн амралтыг биеэр эдлэж чадаагүй шалтгааны тодорхой тусгаагүй, санхүүгийн баримтанд нотлох баримт байхгүй байна.
- Суудлын автомашин ашиглалтын хувьд: Фургон маркийн 2013 онд үйлдвэрлэгдсэн 27.0 сая төгрөгийн анхны өртөг 1 автомашинтай бөгөөд шатахууны зардалд 1.4 сая төгрөгийг зарцуулсан, орон тооны жолоочгүй байна
- Байгууллагын манаач өндөр насны тэтгэвэр тогтоолгож, чөлөөлөгдсөнд нөхөх томилгоо хийж, 2.8 сая төгрөгийн цалин олгосон нь зайлшгүй шаардлагатай албан тушаалын томилгоо хийсэн байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байдаг.

Энэ санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хууль, “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад 2021 онд 119 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгалаа. Хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав. Үүнд:

- Тайлангийн жилд тус байгууллагын Музейн 4 ажилтан УБ хотруу цагдаагийн хэлтэст үзмэр тулгах, сургалтанд хамрагдсан гэж томилолтын зардлаас 718.7 мянган төгрөгийг зарцуулсан боловч сургалт зохион байгуулсан газрын дуудсан албан бичиггүй, илтгэх хуудасгүй зэрэг анхан шатны баримт бүрдүүлэлт хангалтгүй байна. Энэ нь Засгийн Газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.5-д "Салбарын хэмжээнд хийсэн сургалт семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх" гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй байх “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан ба аудитаас зөвлөмж өгөөгүй байна.

Тус байгууллагын 2021 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудитаар анхан шатны баримтын бүрдүүлэлтэй холбоотой 0.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлж биелэлтийг хангуулж ажилласан.

3.11. ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй болно. Иймд Зөрчилгүй дүгнэлт өглөө.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
Музей											
Дүн		0	0	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
Музей											
Дүн		1	0.7	0	0	0	0	0	0	0	0
Нийт дүн		1	0.7	0	0	0	0	1	0.7	0	0